

УЛС, ОРОН НУТГИЙН  
ТӨСВИЙН  
НЭЭЛТТЭЙ  
БАЙДАЛ






ИЛ ТОД  
БАЙДАЛ  
ХУВЬЦАА  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХУДАЛДАН АВАЛТ  
ОРЛОГО  
ЗАРЛАГА

**ОЛОН НИЙТИЙН  
ХЯНАЛТ** 



## ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИАС

ТӨРИЙН АУДИТ  ТӨСВИЙН УДИРДЛАГЫГ ХУУЛИЙН ЭТГЭЭД  
НИЙТ ТӨСӨВТ  ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮ  
ӨРТӨГ  ШИЙДВЭР, ТӨСӨВ   
ХАРИУЦЛАГА  УЙЛ АЖИЛЛАГАА АРХИВ ЦАХИМ ХУУДАС  
МЭДЭЭЛЭЛ

2019

ШИЛЭН ДАНСНЫ  
ТУХАЙ ХУУЛИЙН  
ЗОРИЛТ, ҮЙЛЧЛЭХ  
ХҮРЭЭ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НИЙТЭЛБЭЛ  
ЗОХИХ ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨРИЙН ЧИГ  
ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР  
ТӨСВИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮ, ТӨСВИЙН АСУУДАЛ  
ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ  
БАЙГУУЛЛАГЫН НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ  
ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

ШИЛЭН  
ДАНСНЫ  
ХЯНАЛТ,  
ХАРИУЦЛАГА



## ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, ЗАРЧИМ

**ХУУЛИЙН ЗОРИЛТ** нь улс, орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Доор дурдсан байгууллага, тэдгээрийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна (*Хуулийн 3.1 заалт*):

Төр, орон нутгийн өмчит этгээд	3.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд
Төрийн өмчит үйлдвэр	3.1.2 Төрийн өмчит үйлдвэрийн газар
Төр, орон нутгийн нэгдмэл сонирхолтой этгээд	3.1.3 Хяналтын багц буюу түүнээс дээш хувьцааг нь төр, орон нутаг, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани
Төр, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэгчид	3.1.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ХО, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага
Төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэгчид	3.1.4 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч



### Хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т хамаарах байгууллага бүр:

- Шилэн дансны бие даасан цэстэй байх
- Байрлуулсан мэдээлэл нь татаж авах, хэвлэх боломжтой байх
- Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулах
- Мэдээллээ тогтмол шинэчилж, өмнөх мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой хэлбэрээр архивлах

*Хуулийн 5.1 заалт*



### Бүрэн эхээр нь хавсаргах мэдээлэл

- Холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл

*Хуулийн 6.10 заалт*

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

### ТОДОРХОЙ ХУГАЦААНД НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ (Хуулийн 6.1 заалт)

НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ	ХУГАЦАА	ДАВТАМЖ
Тухайн жилийн төсөв (6.1.1)	1-р сарын 10-ны дотор	
Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (6.1.1)		
Тухайн жилийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт (6.1.1)		
Дараа жилийн төсвийн төсөл (6.1.3)	9-р сарын 15-ны дотор	Жилд нэг удаа
Өмнөх оны төсвийн гүйцэтгэл (6.1.2)	4-р сарын 25-ны дотор	
Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (6.1.4)	7-р сарын 1-ний дотор	
Аудитын дүгнэлтэд туссан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (6.1.5)		
Хагас жилийн төсвийн гүйцэтгэл (6.1.2)	8-р сарын 15-ны дотор	Хагас жил тутамд
Хагас жилийн санхүүгийн тайлан (6.1.4)		
Төсвийн гүйцэтгэлийн улирлын мэдээ (6.1.2)	Дараа сарын 8-ны дотор	Улирал тутамд
Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар (6.1.6)	Улирал бүр	
10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын талаарх мэдээлэл (6.9)		
Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (Хуулийн 6.1.2)	Дараа сарын 8-ны дотор	Сар тутамд

### 7 ХОНОГИЙН ДОТОР НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ (ХУУЛИЙН 6.4 ЗААЛТ)

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (6.4.1)
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (6.4.2)
- Тендерийн баримт бичиг, урилга, шалгаруулалт явуулах журам, оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан ба шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллээс гадна шалгарсан болон шалгараагүй тухай хуулийн үндэслэл, шалтгаан (6.4.3)
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (6.4.4)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр нь агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт (6.4.5)
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (6.4.6)
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (6.4.7)
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах болон өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (6.4.8)
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл (6.4.9)

## ХУВЬЦАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТӨСВИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУУЛИЙН 3.1.3 ДУГААР ЗААЛТАД ХАМААРАХ ЭТГЭЭД (Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани)-ИЙН 7 ХОНОГИЙН ДОТОР НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ

(Хуулийн 6.8 дугаар заалт)

- Тухайн байгууллагад холбогдох доорх шийдвэр: (6.8.1)
  - Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл (3.2.5)
  - Төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс (3.2.7)
  - Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр (3.2.8)
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, урилга, шалгаруулалтын журам, оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт, тендэрт шалгарсан ба шалгараагүй оролцогчдын талаарх товч мэдээллээс гадна шалгарсан болон шалгараагүй тухай хуулийн үндэслэл, шалтгаан (6.8.2)
- Төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт (6.8.3)

ХУУЛИЙН 3.1.4 БА 3.1.5 ДУГААР ЗААЛТАД ХАМААРАХ ЭТГЭЭДИЙН УЛИРАЛ ТУТАМД НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ

- Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага
- Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хөрөнгөөр төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

(Хуулийн 6.9 заалт)

### МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ

Хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээний талаарх:

- нийт төсөвт өртөг;
- хэрэгжилтийн явц, үе шат;
- зарлага, санхүүжилтийг мэдээлнэ.

### МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ ТАЛБАР

Хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд

## САНХҮҮ, ТӨСВИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ



САНГИЙН ЯАМ

САНГИЙН ЯАМ НЬ ЭНЭ ХУУЛИЙН 6.1, 6.4-Т ЗААСАН МЭДЭЭЛЛЭЭС ГАДНА ДАРААХ  
МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАНА (Хуулийн 6.5 заалт).

НИЙТЭЛБЭЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ	ХУГАЦАА	ДАВТАМЖ
- Өмнөх жилийн улсын төсөв, жилийн эцсийн байдлаар (6.5.1)		
- Өмнөх жилийн нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт (6.5.1)	1-р сарын 15-ны дотор	Жилд нэг удаа
- Өмнөх жилийн төсвийн нэгдсэн үзүүлэлт (6.5.1)		
- Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан (6.5.6)	8-р сарын 25-ны дотор	
- Улсын төсөв, хагас жилийн байдлаар (6.5.1)		
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, хагас жилийн байдлаар (6.5.1)	7-р сарын 15-ны дотор	Хагас жил тутамд
- Төсвийн нэгдсэн үзүүлэлт, хагас жилийн байдлаар (6.5.1)		
- Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээ (6.5.2)		
- Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл (6.5.3)		
- Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар (6.5.4)		
- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл (6.5.7)		Улирал бүр
- Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл (6.5.11)		
- Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо (6.5.12)		
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээ (6.5.5) (сарын бүрийн 15-ны дотор)		Сар бүр
- Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш (6.5.8)		
- Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш (6.5.9)		7 хоногийн дотор
- Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нүүцэд хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл (6.5.10)		



## ШИЛЭН ДАНСНЫ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

### ШИЛЭН ДАНСНЫ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ (Хуулийн 8.1 заалт)



Бүх шатны Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурал



Бүх шатны Иргэдийн  
Нийтийн Хурал



Төрийн аудитын  
байгууллага

### ДОТООД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ (Хуулийн 8.2 заалт)



ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧ

Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно (Хуулийн 8.4 заалт).

### ИРГЭНИЙ ХЯНАЛТ

- Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно. (Хуулийн 9.1 заалт)
- Төрийн аудитын байгууллага нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн иргэнд бичгээр өгөх ба олон нийтэд мэдээлнэ. (Хуулийн 9.2 заалт)
- Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй. (Хуулийн 9.3 заалт)



ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД  
ХҮЛЭЭЛГЭХ  
ХАРИУЦЛАГА

Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. (Хуулийн 10.1 заалт)